



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 12 өдөр

Дугаар A/544

Булган сум

**Булган сумын халаалт, дулааны эрсдэлт нөхцөл
байдалд үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.8, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 7 дугаар зүйлийн 7.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.12 дахь заалт, Булган аймгийн Онцгой комиссын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 2025-2026 оны төв суурины өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх холбогдох албан тушаалтнуудаас хийсэн мэдээллээр халаалтын улиралд Булган сумын иргэн, аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагуудыг дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагаанд эрсдэл үүссэн тул “гамшгийн эрсдэл” үүссэн гэж тогтоож, Булган сумын халаалт, дулааны эрсдэлт нөхцөл байдалд үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн дарга: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд:
- Г.Нарангэрэл (Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалт хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
 - Г.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
 - С.Цэдэнлхам: (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
 - Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
 - Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
 - Б.Болдбаатар (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа)
 - С.Одончимэг (Булган аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга)

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

0325010749

